

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны дугаар
ны өдөр

Улаанбаатар сарын.....-
хот

БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Байгаль орчныг хамгаалах тухай хуульд дор дурдсан агуулгатай дараахь зүйлийг нэмсүгэй.

1/12 дугаар зүйл. Байгаль орчны төлөв байдлын тайлан

1. Засгийн газар байгаль орчны төлөв байдлын талаархи тайланг хоёр жилд тутам 1 удаа Улсын Их Хурлын хаврын чуулганд өргөн мэдүүлэх бөгөөд түүнд дараахь асуудлыг тусгана:

1/байгалийн баялгийг хамгаалах, нөхөн сэргээхэд зориулсан улсын төсвийн ба тусвийн бус хөрөнгийн зарцуулалт;

2/байгаль орчны төлөв байдлын болон байгалийн баялгийн нөөцийн хувьсал өөрчлөлт;

3/байгалийн баялгийн нөөцийн ашиглалт, нөхөн сэргээлт;

4/орчны бохирдлын эх үүсвэр, түвшин, түүнийг бууруулах талаар авсан арга хэмжээ, үр дүн.

2 дугаар зүйл. Байгаль орчныг хамгаалах тухай хуульд дор дурдсан агуулгатай хэсэг, заалт нэмсүгэй:

1/ Хуулийн 14 дүгээр зүйлийн¹ 5 дахь хэсэг: “Байгалийн тодорхой баялгийг хариуцан хамгаалах, ашиглах, эзэмших талаар байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлийн баримтлах журмыг батлах” гэж;

2/ Хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн² 7 дахь заалт: “нутаг дэвсгэртээ нөхөрлөлийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах **зардлыг** байгалийн нөөц ашигласны төлбөрийн **орлогын хэсгээс тухайн орон нутгийн төсөвт тусган баталж, зарцуулалтад** хяналт тавих” гэж;

3/ Хуулийн 33 дугаар зүйлийн 23 дахь хэсэг: “Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлүүдийн талаархи мэдээлэл” гэж;

4/ Хуулийн 58 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 7 дахь заалт: “**энэ хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, 2 дахь хэсгийн 7 дахь заалт, 17 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, 2 дахь хэсгийн 2, 10-т заасан үүргийг биелүүлээгүй албан тушаалтаныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох**” гэж;

Здугаар зүйл. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн дараахь хэсэг, заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ Хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 8 дахь заалт: “байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл гэж /цаашид “нөхөрлөл” гэх/ нутгийн иргэдэд байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх эрхийг олгож, нөөц ашиглалтыг хамтаараа, ил тод, шударга зарчимд нийцүүлэн зохион байгуулж, түүнээс гарсан үр ашгийг тэнцүү хуваарилах

зорилготой **Иргэний хуулийн 25.1-д⁶¹ заасан шинжийг агуулсан хуулийн этгээдийг**” гэж өөрчлөн найруулах;

2/Хуулийн 16 дугаар зүйлийн **2 дахь хэсгийн⁶⁴ 7 дахь заалт**: “нутаг дэвсгэртээ нөхөрлөлийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх зардлыг байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгээс санхүүжүүлж, шаардлагатай бусад дэмжлэгийг үзүүлж ажиллах” гэж;

3/ Хуулийн 17 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн⁶⁵ 7 дахь заалт: “нутаг дэвсгэртээ нөхөрлөлийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын **хэсгээс тухайн орон нутгийн төсөвт тусган баталж, зарцуулалтад** хяналт тавих” гэж;

4/ Хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2 дахь заалт: “нөхөрлөлийн гэрээгээр хариуцан хамгаалж байгаа газар нутагт иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад байгалийн баялгийн нөөцашиглах эрхийг олгохдоо тухайн нөхөрлөлтэй зөвшилцөх” гэж;

5/Хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн⁶⁶ 10 дахь заалт: “нөхөрлөлийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх зардлыг байгалийн нөөц ашигласны төлбөрийн **орлогын хэсгээс санхүүжүүлж** хамтран ажиллах, үр дүнг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнах” гэж;

6/Хуулийн 50 дугаар зүйлийн 7 дахь хэсэг: “**Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл ньнийгмийн тусын тулд үйл ажиллагаа явуулдаг, ашгийн төлөө бус хуулийн этгээд бөгөөд үйл ажиллагаагаа Төрийн бус байгууллагын тухай хуульд нийцүүлэн эрхлэнэ**” гэж;

7/Хуулийн 50 дугаар зүйлийн 14 дэх хэсэг:“**Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлийг улсын бүртгэлд бүртгэх, гэрчилгээ, тэмдэг олгох тусгайлсан журмыг Байгаль орчны болон Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран баталж, бүртгэлийг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хууль тогтоомжийн дагуу хөтлөн явуулна**”гэж;

8/ Хуулийн 54 дүгээр зүйлийн⁷¹ 1 дэх хэсэг: “Байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчинд үзүүлэх хортой аюултай нөлөөллийг багасгах дэвшилтэт арга, хоргүй, аюулгүй, бохирдолгүй, хаягдалгүй технологи нэвтрүүлсэн иргэн, **нөхөрлөл**, аж ахуйн нэгж, байгууллагыг төрөөс урамшуулна.” гэж;

9/ Хуулийн 54 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг: “Энэ хуулийн 1 дэх хэсэгт заасны дагуу иргэн, **нөхөрлөл**, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах журмыг Засгийн газар тогтооно.” гэж;

10/ Хуулийн 54 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг: “Байгаль орчны хууль тогтоомж зөрчсөн тухай үнэн бодит мэдээллийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд өгсөн, түүнчлэн зөрчлийг илрүүлсэн, илрүүлэхэд бодитой туслалцаа үзүүлсэн иргэн, **нөхөрлөлд** зөрчил гаргагчид ногдуулсан торгууль, нөхөн төлбөрийн орлогын дүнгийн 15хувьтай тэнцэх мөнгөн урамшууллыг сум, дүүргийн Засаг дарга олгоно.” гэж;

11/ Хуулийн 54 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг: “Хууль бусаар бэлтгэж хураалгасан байгалийн баялгийн борлуулалтын орлогын 15 хувийг тухайн зөрчлийг илрүүлсэн улсын байцаагчид мэргэжлийн хяналтын байгууллага, байгаль хамгаалагч, **идэвхтэн байгаль хамгаалагчид** тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга олгоно.” гэж.

4 дүгээр зүйл:

Энэ хуулийг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны дугаар сарын
.....-ны өдөр

Улаанбаатар
хот

**АМЬТНЫ ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Амьтны тухай хуулийн дараахь заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ Хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалт: “агнуурын нөөцийг хариуцан хамгаалах, ашиглах, эзэмших талаар Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт заасан журмыг мөрдөж ажиллах” гэж;

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2016 оны сарын-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ